

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**БНЭУ: ЭВСЭЛД ҮЛ НЭГДЭХ ГАДААД
БОДЛОГО, ТҮҮНИЙ ХӨГЖИЛ БЭХЖИЛТ****Д. Пүрэв**

Энэтхэгийн эвсэлд үл нэгдэх гадаад бодлого дахь империализм, шинэ колоничлолын эсрэг чиглэсэн идэвхтэй үйл ажиллагаа нь олон улсын тавцанд түүний нэр хүнд өсөн бэхжихийн нэг чухал хүчин зүйл болж байна.

Империализм, колоничлолын түрэмгий бодлогын эсрэг энх тайван, улс түмний хамтын ажиллагааг бататгахад чиглэсэн Энэтхэг улсын гадаад бодлогын үндсэн зарчмууд Английн империализмын колонийн дарлалын эсрэг Энэтхэгийн ард түмэн улс орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэж байсан үед бүрэлдэн тогтсон бөгөөд түүний үндсийг Энэтхэгийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэрт удирдагч БНЭУ-ын анхны ерөнхий сайд Жавахарлал Неру тавьсан билээ. Дэлхийн II дайны дараа идэвхтэй өрнөсөн Азийн улс түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний жилүүдэд Энэтхэгийн нийгмийн тэргүүний хэсгийн дунд колонийн дарлал, мөлжлөгийн эсрэг үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө тэмцлийн үзэл санаа өргөн дэлгэрч байв. Мөн бусад орны ард түмэнтэй эв санааны бат нэгдэлтэй байх үзэл ч тэднийг эзэмдэж байлаа.

Колоничлолын бүхий л хэлбэрийн эсрэг Азийн улс түмний тэмцлийг эрчимжүүлэхэд Жавахарлал Неругийн санаачилгаар 1947 оны 3-р сарын 23-наас 4-р сарын 2-нд Дели хотод хуралдаж, Азийн улсуудын харилцааны асуудлыг авч хэлэлцсэн Азийн анхдугаар бага хурал чухал үйл явдал болсон юм. Тус бага хурлын ажиллагаанд Азийн 28 орны төлөөлөгчид, түүний дотор БНМАУ, Зөвлөлтийн дундад Ази, Кавказын Бүгд Найрамдах Улсуудын олон нийтийн байгууллагын төлөөлөгчид оролцжээ. Бага хурал дээр Ж. Неру хэлсэн үгэндээ: «Азийн ард түмэн олон зуун жилийн туршид өрнөдийнхний өмнө өвдөг сөхрөн элдвийг гуйж байсан тэр цаг нэгэнт өнгөрч, Ази олон улсын хэрэгт өөрийн гэсэн бодлого явуулах цаг ирж байна»¹ гэж цохон тэмдэглэж байв. Империализм, колоничлолын эсрэг тэмцэх үндсэн дээр Азийн ард түмний эв санааны нэгдлийг хангах гэсэн Ж. Неругийн санааг бага хуралд оролцсон төлөөлөгчид баяртайгаар хүлээн авсан билээ.

Энэтхэгийн ард түмнээс харийн дарлал, мөлжлөгийн эсрэг хийсэн тэмцлийн явцад үндэс суурь нь тавигдсан тус орны гадаад бодлогын гол зорилт нь төрийн тусгаар тогтнолыг бэхжүүлэх, үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хангах, бусад улс түмэнтэй энх тайван,

1. «Проблемы Дальнего Востока», № 2, 1983, с. 29.

найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна. Ж. Неру эвсэлд үл нэгдэх бодлогыг Энэтхэгийн үндэсний болон олон улсын энх тайвныг бэхжүүлэх ашиг сонирхолд бүрэн дүүрэн нийцэх бодлого гэж үзэж байв. Колонийн дарлалаас дөнгөж ангижрсан Энэтхэг улс эдийн засгийн хоцрогдлоос гарахад гадаадын тусламжинд нэлээд хэмжээгээр түшиглэх шаардлагатай боловч цаашдаа империалист гүрнүүдийн хараат байдлаас ангижрах, цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байх, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулж, эвсэлд нэгдээгүй улсууд болон олон улсын харилцааг тогтворжуулж буй хүчнүүдийн оролцоотойгоор «энх тайвны бүс» байгуулах замаар энх тайвныг бэхжүүлж болно² гэж Неру үзэж байв. Тийм ч учраас Ж. Неру империализм, колониаллолын эсрэг энх тайвны өргөн фронт байгуулах үзэл санааг өргөн сурталчилж байсан юм.

Энх тайван, аюулгүй байдлыг хамтын хүчин чармайлтаар сахин хамгаалах, цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, зэвсэглэлийн хойноос хөөцөлдөх явдлыг зогсоох, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, Энэтхэгийн салбар тив, Баруун болон Зүүн Өмнөд Азийн орнуудын харилцааг хэвийн болгож, энх тайван, тогтвортой байдлыг хангах, Ойрхи Дорнодын хямралыг улс төрийн аргаар зохицуулах байр суурь бол Энэтхэг улсын эвсэлд үл нэгдэх бодлогын үндсэн чиг шугам юм.

Энэтхэгийн гадаад бодлогын энэ үндсэн чиг шугам нь үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэл, шинэ тулгар тусгаар тогтнолоо олсон ард түмнээс улс төр, эдийн засгийн тусгаар байдлаа бэхжүүлэхийн төлөө империализмын эсрэг явуулж буй тэмцлийн ашиг сонирхолд бүрэн дүүрэн нийцэж байдаг учраас Энэтхэг болон Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудаас империализм, шинэ колониаллолын эсрэг явуулж буй тэмцлийн нийтлэг үндэс болж байна.

Энэтхэг улс өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлыг нийт Ази тивийн хурцадмал байдлыг намжаах, энэ бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг бий болгох, улмаар олон улсын тулгамдсан асуудлуудыг энх тайван, хэлэлцээний замаар шийдвэрлэх, нийтийн зорилгод нягт уялдсан гадаад бодлогыг явуулж ирсэн нь Энэтхэг улсын олон улсын нэр хүнд өсөн бэхжихийн нэг чухал хүчин зүйл болжээ.

Эвсэлд үл нэгдэх Энэтхэгийн гадаад бодлогын идэвхтэй үйл ажиллагаа нь империалист гүрнүүдээс Азийн зарим улс орныг цэргийн түрэмгий эвсэл холбоонд татан оруулах, бусдын нутагт цэргийн түрэмгий бааз байгуулах явдлыг тууштай эсэргүүцэж байгаагаар илэрч байгаа юм. Энэтхэг улс тухайн үедээ СЕНТО, СЕАТО зжржг цэргийн империалист эвсэл холбоог татан буулгахыг идэвхтэй дэмжиж байсан бөгөөд өнөө үед Диего-Гарси аралд байгаа Америкийн цөмийн цэнэг бүхий цэргийн баазыг татан буулгах, олон улсын худалдаа эдийн засгийн чухал зангилаа бүс нутаг—Энэтхэгийн далайг цөмийн зэвсгээс чөлөөт, энх тайван, хамтын ажиллагааны бүс болгох, Энэтхэгийн далайн асуудлаар олон улсын бага хурал хийлгэхийн төлөө идэвхтэй тэмцэж байна.

Энэтхэг улс Ази, Африкийн улсуудын болон олон улсын харилцааны хэд хэдэн чухал зарчмыг санаачилан боловсруулахад идэвхтэй оролцсон юм. Энэтхэг улсын санаачилга, идэвхтэй оролцоотойгоор

тунхагласан «Панча Шила» одоо үед нийгмийг янз бүрийн байгуулал бүхий улсуудын хоорондын харилцааны нэг чухал зарчим болсоор байна.

Пуужин, цөмийн зэвсгийн эрин үед зөвхөн энх тайван, тогтвортой байдлын нөхцөлд шинэ залуу улс орнууд өөрийн хөгжлийн хойшлуулшгүй зорилтуудыг шийдвэрлэж чадах билээ.

60-аад оны үүсч бий болсон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг санаачлагчдын нэг нь Энэтхэг улс юм. Таван тивийн 100 гаруй улс орны эгнээндээ багтаасан эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний улс төрийн үндсэн чигийг боловсруулах, түүнийг зохион байгуулалтын хувьд бэхжүүлэхэд Ж. Неру үнэт хувь нэмэр оруулсан юм.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн өнөөдөр империализм, колоничлолын эсрэг улс түмний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахын төлөө тэмцэлд улс төрийн нөлөө бүхий хүч болж, олон улсын эдийн засгийн шударга дэг журам тогтоох, цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, колончилал, арьсны үзлийн эсрэг явуулж буй бүх нийтийн тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэж байна. 1983 онд Энэтхэгийн нийслэл Дели хотод хуралдсан нэнэ хөдөлгөөний ээлжит VII бага хурал нь Ази, Африк, Латин Америкийн орнуудын өмнө тулгарч буй зорилтууд болон орчин үеийн дэлхий дахины нэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хөдөлгөөний нэгдэл нягтралыг хангах асуудалд гол анхаарлаа төвлөрүүлсэн юм.

Делийн бага хурлын шийдвэрийг амьдралд тууштай хэрэгжүүлж империализм, шинэ колоничлолын эсрэг энх тайван, аюулгүй байдал, үндэсний тусгаар тогтнолыг бэхжүүлэхийн төлөө тэмцэлд эвсэлд нэгдээгүй орнуудын хүчин чармайлтыг нэгтгэхэд энэ хөдөлгөөнийг толгойлж байгаагийн хувьд Энэтхэг улсад өндөр үүрэг, хариуцлага ноогдож байгаа юм. Энэтхэг улс эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд үнэнч байж, уг хөдөлгөөнийг бүх талаар бэхжүүлэх шийдвэр төгс байгаа тухай энэ хөдөлгөөний дарга, БНЭУ-ын Ерөнхий сайд Ражив Ганди саяхан мэдэгдлээ.

БНМАУ-ын засгийн газар олон улсын харилцааны идэвхтэй хүчин зүйл болсон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний зорилго, үйл ажиллагааг гүнээ хүндэтгэж, империалист дарлал мөлжлөг, түрэмгийлэл, шинэ колоничлол, их гүрний жанжлах бодлогын эсрэг тэмцэж байгаа ард түмэнтэй ямагт эв санааны нэгдэлтэй байж, олон улсын үйл хэрэг дэх эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн болон Энэтхэг улсын үүрэг ролийг өндөр үнэлж байдаг билээ.

Саяхан Энэтхэгийн ерөнхий сайд Ражив Гандийн санаачилгаар Делид Аргентин, Грек, Энэтхэг, Мексик, Танзани, Шведын төр, засгийн тэргүүн нарын уулзалт болов. Энэхүү дээд хэмжээний зөвлөлгөөнөөс цөмийн зэвсэгтэй гүрнүүд, түүнчлэн бүх дэлхийн ард түмэн, парламент, засгийн газруудад хандаж, цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөхийг нэн даруй зогсоох, цөмийн зэвсгийн санг хорогдуулж, улмаар устгах, цөмийн дайн гарах аюулыг арилгахын тулд шаардлагатай бүх арга хэмжээ авах тухай уриалга гаргав.³ Мөн дээрх уулзалтаас ЗХУ, АНУ хоёр сансрын болон цөмийн зэвсэглэлтэй холбогдолтой бүх иж бүрэн асуудлаар хоёр талын хэлэлцээ хийхээр энэ оны 1-р сард Женевт хэлэлцэн тохиролцсон явдалд баяр хүргээд, цөмийн зэвсэг болон түүнийг байд хүргэгч системийг турших, үйлдвэрлэх, байрлуулахыг нэлэнхүйд нь зогсоохыг цөмийн зэвсэгтэй гүрнүүдэд уриалжээ. Де-

3. «Үнэн», 1985. 1. 30.

лийн зөвлөлгөөн нь хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангах, цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах тэмцэлд дэлхийн олон нийтийн анхаарлыг төвлөрүүлэхэд бас нэг чухал үйл явдал болов.

Энэтхэгийн засгийн газар хөрш зэргэлдээ улсуудтайгаа хэвийн харилцаа, үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт тавьж байна. Энэтхэг Пакистантай харилцаагаа Симлагийн 1972 оны хэлэлцээрийн үндсэн дээр зохицуулах, улс төр, эдийн засаг, худалдаа, соёлын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, 1981 оноос хойш тус хоёр орны хооронд хийгдэж байгаа улс төрийн зөвлөлдөөнийг үр дүнд хүргэх, Пакистантай энх тайван, найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байгуулахын төлөө байна.

Энэтхэг улс 1949 оны 12-р сарын 30-нд БНХАУ-ыг хүлээн зөвшөөрсөн билээ. Энэ нь БНХАУ-ын тэр үеийн олон улсын байдлыг бэхжүүлэхэд чухал дэмжлэг болсон юм. Энэтхэг, Хятад хоёр улсын хооронд тогтсон найрамдалт харилцаа, хамтын ажиллагаа Ази тивийн тус хоёр их ард түмний болон бусад улс түмний язгуур эрх ашигт нийцэн амжилттай хөгжиж байв. Өнөө үед Энэтхэгийн засгийн газар тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, тэгш эрх, харилцан бие биеэ хүндэтгэх, дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмын үндсэн дээр Хятадтай харилцаагаа хэвийн болгоход ихээхэн хүчин чармайлт тавьж байна.

ЗХУ, БНМАУ, социалист бусад оронтой тогтоосон найрамдалт харилцаа, олон талт хамтын ажиллагаанд Энэтхэг улс их ач холбогдол өгч байна.

Бүгд Найрамдах Энэтхэг улс оршин тогтнож ирсэн хугацаандаа империализм, жанжлах үзэл, Энэтхэгийн дотоод, гадаадын харгис хүчний зүгээс Энэтхэгийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн байдалд заналхийлсэн элдэв оролдлоготой нэг биш удаа тулгарч, тэдгээрт няцаалт өгсөөр байна. Тэд Энэтхэг улсын сонгон авсан гадаад бодлогын энхийг эрхэмлэсэн, эвсэл холбоонд үл нэгдэх тууштай чиг шугамыг өөрчлөх, өрнөдийн цэрэг-улс төрийн бодлогын хүрээнд Энэтхэгийг татан оруулах, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай тогтоосон найрамдалт харилцаа, үр ашигтай хамтын ажиллагаанд саад тотгор хийхийг янз бүрийн хэлбэрээр оролдож ирсэн боловч Энэтхэг улс эвсэлд үл нэгдэх бодлогынхоо үндсэн зарчмыг тууштай хамгаалж, улс орныхоо нэгдэл нягтралыг улам тогтворжуулж байгааг Энэтхэг дэх сүүлийн үеийн хэрэг явдлууд тод харуулж байна.

Энэтхэг улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс үндэснийхээ нэгдлийг хангах талаар Жавахарлал Неру, Индира Ганди нарын үндсийг нь тавьж хэрэгжүүлж ирсэн эвсэлд үл нэгдэх гадаад бодлого, мөн эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, империализмын эсрэг түүний чиг шугамыг бэхжүүлэхийн төлөө Ерөнхий сайд Ражив Гандийн засгийн газрын гадаад бодлогод БНМАУ өндөр ач холбогдол өгч, түүнийг олон улсын байдлыг тогтворжуулах чухал хүчин зүйлийн нэг гэж үзэж байна.

РЕСПУБЛИКА ИНДИИ: ПОЛИТИКА НЕПРИСОЕДИНЕНИЯ, ЕЕ ФОРМИРОВАНИЕ И РАЗВИТИЕ

(Резюме)

В статье автор рассказывает о формировании политики непри соединения одного из крупнейших государств Азии—Республики Индии и ее роли в деле сохранения и укрепления всеобщего мира и безопасности народов. В статье говорится, что основателем Респуб-

лики Индии и её миролюбивой внешней политики является Джавахарлал Неру-один из руководителей национально-освободительного движения индийского народа. Он сыграл большую роль направленности политики неприсоединения Индии.

Приверженность к делу мира, борьба за обеспечение равноправия как в политических, так и в экономических отношениях между газартай байсны государствами, нетерпимость к проявлениям империализма, расизма, колониализма напартеида — таковы основные принципы политики неприсоединения, проводимой правительством Индии.

Антимпериалистический, миролюбивый курс внешней политики Индии создает благоприятные условия для преодоления отсталости, унаследованной страной от грабительского колониального господства британского империализма и способствует дальнейшему возрастанию роли Индии в международных делах.

Автор статьи делает вывод, что движение неприсоединения, одним из инициаторов которого является Индия, ныне становится одним из влиятельных, прогрессивных факторов в международных отношениях. Индия, являясь одним из активных членов этого движения, играет важную роль в укреплении антиимпериалистической на правленности движения неприсоединения и вносит большой вклад в борьбу народов за укрепление мира и безопасности в Азии и во все мире.

ХУВЬСГАЛТ ОЛОЛТОО БАТАТГАЖ БАЙГАА НЬ

Б. Батболд

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Никарагуагийн ард түмний хагас зуун жил шахам талхин дарлаж байсан Латин Америкийн хамгийн харгис дэглэмийн нэг болох Сомосын дарангуйлал зэвсэг барин боссон ард түмний тэмцлийн үр дүнд одоогоос зургаан жилийн өмнө түлхэгдэн унасан билээ.

Никарагуагийн ард түмний хувьсгалт тэмцлийг Сандиногийн үндэсний Чөлөөлөх фронт (СҮЧФ) удирдсан юм. Никарагуа дахь шинэ амьдралын үйл явц эдүгээ нарийн төвөгтэй нэлээд бэрхшээлтэй нөхцөлд явагдаж байна. 1979 оны 7-р сарын 19-нд ялсан хувьсгалын анхны өдрөөс эхлэн Төв Америкийн энэ орны ард түмэн хоёр фронт дээр нэгэн зэрэг тэмцэл явуулсаар байна. Үүнд нэг талаас хуучин нийгмийн хүнд бэрх хоцрогдлыг гэтлэн давах, нөгөө талаас эрх чөлөө, тусгаар тогтнолоо хувьсгалын дайснуудаас зэвсэг барин хамгаалах явдал болж байна.

Сандиногийн ардын хувьсгалын ялалтаас хойшхи өнгөрсөн таван жилд Никарагуагийн нийгмийн амьдралд гүн гүнзгий дэвшилт өөрчлөлтүүд гарлаа. Юуны өмнө тус оронд хувьсгалт ардчилсан төр тогтож, улс төрийн шинэ системийн үндэс тавигдан нийгэм—эдийн засгийн чухал өөрчлөлт, шинэтгэл хийгдэв.

Одоогийн дотоод, гадаадын ээдрээтэй, хүнд нөхцөлд Никарагуагийн үндэсний сэргэн мандалтын засгийн газар Сомосын харгис дэглэмийн үлдээсэн хуучин нийгмийн эрх тэгш бүс, байдал, эдийн зас-